



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалт, мөн зүйлийн 34.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсэг, Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 325 дугаар тогтоол, Төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж буй үйл ажиллагааны 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн тайлангийн хурлын 2020/001 дугаартай тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай” 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 2019/31 тоот гэрээний биелэлтийг хэлэлцсэн ажлын хэсгийн санал, дүгнэлтийн дагуу “Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах” чиг үүргийг барилгын салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллагуудын /12/ түншлэлийг төлөөлж “Монголын Барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 3 /гурван/ жилийн хугацаатай үргэлжлүүлэн гүйцэтгүүлсүгэй.

2. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээг 3 /гурван/ жилийн хугацаатай барилгын салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллагуудын /12/ түншлэлийг төлөөлж “Монголын Барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллага /М.Батбаатар/-тай байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.

3. Дээрх чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэхтэй холбогдуулан төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хамтын ажиллагааг өргөжүүлэн барилгын салбарын ажилтны мэдээллийн санг хамтран ашиглаж сургалтын чиглэлээр баяжилтыг тогтмол хийж, сургалтын зориулалтын анги танхим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг бүрэн хангаж хамтран ажиллахыг “Монголын Барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллага /М.Батбаатар/, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирал /Ц.Амарсанаа/ нарт даалгасугай.

4. Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаал, “Барилгын

151010066

салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн дүрэм” батлах тухай Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 155 дугаар тушаал, “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрмийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 209 дүгээр тушаалыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг “Монголын Барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллага /М.Батбаатар/-т даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Х.БАДЕЛХАН